



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 541

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын
хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар" Төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 44,715,060.00 /дөчин дөрвөн сая долоон зуун арван таван мянга жаран/ төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн цаашид ашиглаж болох автомашины ашиглах хугацааг сунгаж, үнийг 22,357,530.00 /хорин хоёр сая гурван зуун тавин долоон мянга таван зуун гуч/ төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. "Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар" Төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Ичинхорлоо, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын дарга Б.Бат-Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг хүлээлцэх, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн
541.....дугаар тогтоолын хавсралт



Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
үлдэх өртөггүй, ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоон Шударга
өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт балансаас балансад шилжүүлэх автомашин

№	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн, ашиглалтанд орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил
1	Нисса Теана маркийн суудлын автомашин улсын дугаар 04-82 УБЗ, арлын дугаар JN1BAUJ32Z0000116	2008/2008	44,715,060.00	22,357,530.00	3
2	Нийт дүн		/Дөчин дөрвөн сая долоон зуун арван таван мянга жаран төгрөг	/Хорин хоёр сая гурван зуун тавин долоон мянга таван зуун гучин төгрөг	